

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/37/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 93

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ардын дуу бүжгийн “Алтай” чуулгын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ардын дуу бүжгийн “Алтай” чуулгын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ардын дуу бүжгийн “Алтай” чуулга нь 1500 гаруй хүний өргөн бүрэлдэхүүнтэй “Тууль хайлах” арга хэмжээ, Хантайшир уулын аймаг үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд Говь-Алтай аймгийн алдартан гавьяатууд оролцсон “Хантайшир-100” тоглолтыг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 130,678.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүй хүлээн авсан 24,100.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч, 42,173.9 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 2 хөтөлбөр, 4 зорилт, 31 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 28 арга хэмжээг 100 хувь, 3 арга хэмжээг 90 хувь нийт дүнгээр 99.0 хувиар тайлагнасан бөгөөд дээд шатны байгууллагаас үнэлээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	254,149.0	292,955.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,382,910.7	6,253,252.5
Нийт хөрөнгийн дүн	6,637,059.7	6,546,207.7
Нийт өр төлбөрийн дүн	-	2,302.0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,637,059.7	6,547,105.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,637,059.7	6,549,407.7
Үйл ажиллагааны орлогын дүн	1,690,751.3	2,097,184.4
Үйл ажиллагааны зардлын дүн	1,695,100.7	2,187,138.4
Үйл ажиллагааны үр дүн	(4,349.4)	(89,954.0)
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	(4,349.4)	(89,954.0)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,987.2	6,637,059.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(1,200.0)	-
Тайлант оны үр дүн	6,560,272.5	(89,954.0)
Эцсийн үлдэгдэл	6,637,059.7	6,547,105.7
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,572,963.6	1,552,309.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,480,893.2	1,411,631.7
Үйл ажиллагааны ЦМГ	92,070.4	140,678.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(72,745.0)	(133,878.5)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	19,325.4	6,799.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19,325,411.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,325,411.6	26,124,910.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,516,272.2	1,545,510.3
Урсгал зардал	1,516,260.0	1,545,510.3
Хөрөнгийн зардал	12.2	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,535,585.4	1,552,309.8
Улсын төсвөөс санхүүжих	989,520.1	1,457,823.2
Орон нутгийн төсвөөс санхүүжих	526,774.3	-
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	19,291.0	94,486.6

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 48,496.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Хуультай холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 3,123.0 мянган төгрөгийг нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.
- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Худалдан борлуулагдсан 42,173.9 мянган төгрөгийн дансны үнэтэй авто тээврийн хэрэгслийг данс бүртгэлээс хасаагүй,
- Тайлант онд байгуулсан гэрээний дагуу 3,200.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч тухайн хөрөнгийг ирээгүй байхад орлого авсан, биет тооллогоор дутагдаж авлагаар тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна

Залруулагдаагүй нийт 19,183.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 19,183.1 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрч 1,763.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн 1 акт тогтоож, 17,420.0 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад 1,609.8 мянган төгрөгийн, даргын тушаал шийдвэргүйгээр 153.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-т "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт " Төрийн албан хаагчид мөнгөн урамшил олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно", 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" 2.7-т "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

урамшуулал олгохгүй" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад олгосон урамшууллын мөнгийг төлүүлж орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр байгууллагын даргын шийдвэрээр нягтлан бодогчийн үндсэн цалин нэмэгдүүлсэн нь Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 2-т "Салбарын онцлог, гүйцэтгэлд суурилсан үр дүнг харгалзан үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг цалингийн доод хэмжээнээс нэмэгдүүлэх асуудлыг тухайн жилийн батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд зохицуулж шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй", Засгийн газрын 2023 оны 241-р тогтоолын 2-т "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлсэн шийдвэрийг холбогдох хууль эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Ажлаас чөлөөлөгдсөн 14 ажилтанд амралтын цалингийн дуусгалтын тооцоо хийгээгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийг 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна", 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох; ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд амралтын цалингийн дуусгалын тооцоог хууль журмын дагуу хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Батлагдсан бүтэц орон тоонд байхгүй 9 албан тушаалд ажил хавсран гүйцэтгүүлсний нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; "Байгууллагын даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаал" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд амралтын цалингийн дуусгалын тооцоог хууль журмын дагуу хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Эдийн засгийн ангилал зөрчиж цалингийн сангийн төсвөөс 6,649.0 мянган төгрөгийг гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын хөлсөд, бараа үйлчилгээний зардлын төсвөөс 5,000.0 мянган төгрөгийн урсгал засварын материалд, цалингаас 2,771.0 мянган төгрөгийг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

5. Өөрийн байгууллагын ажилтанд шинэ уран бүтээлийн хөлс 3,000.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2 Тайлант онд байгуулсан гэрээний дагуу 3,200.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч тухайн хөрөнгийг ирээгүй байхад орлого авсан, биет тооллогоор дутагдаж авлагаар тусгасан	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
		1	3,200.0	-	-	1	3,200.0	1	3,200.0	-	-	-	-
Ардын дуу бүжгийн "Алтай" чуулга	Худалдан борлуулагдсан 42,173.9 мянган төгрөгийн дансны үнэтэй авто тээврийн хэрэгслийг данс бүртгэлээс хасаагүй.	1	42,173.9	-	-	1	42,173.9	1	42,173.9	-	-	-	-
	Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 3,123.0 мянган төгрөгийн гүйлгээ байна	1	3,123.0	1	3,123.0	-	-	1	3,123.0	-	-	-	-
Дүн		3	48,496.9	1	3,123.0	2	45,373.9	3	48,496.9	-	-	-	-

Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:													
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн							
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12						
	Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад 1,609.8 мянган төгрөгийн, даргын тушаал шийдвэргүйгээр 153.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон	1	1,763.10	1	1,763.1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр байгууллагын даргын шийдвэрээр нягтлан бодогчийн үндсэн цалин нэмэгдүүлсэн.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Ажлаас чөлөөлөгдсөн 14 ажилтанд амралтын цалингийн дуусгалтын тооцоо хийгээгүй.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Батлагдсан бүтэц орон тоонд байхгүй 9 албан тушаалд ажил хавсран гүйцэтгүүлсний нэмэгдэл олгосон	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Өөрийн байгууллагын ажилтанд шинэ уран бүтээлийн хөлс 3,000.0 мянган төгрөгийг олгосон.	1	3,000.00	-	-	1	3,000.00	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Эдийн засгийн ангилал зөрчиж цалингийн сангийн төсвөөс 6,649.0 мянган төгрөгийг гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын хөлсөд, бараа үйлчилгээний зардлын төсвөөс 5,000.0 мянган төгрөгийн урсгал засварын материалд, цалингаас 2,771.0 мянган төгрөгийг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулсан.	1	14,420.00	-	-	1	14,420.00	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт		6	19,183.10	1	1,763.10	5	17,420.00	-	-	-	-	-	-	-	-	-	-



Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгаасан нийцлийн аудитын асуудал

/Мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн	Үүнээс:											
		Алдаа, зөрчлийн товч утга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
Ардын дуу бүжгийн "Алтай" чуулга	Тайлант онд 24,932.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна	1	24,932.00			1	24,932.0						
	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 19,328.1 мянган төгрөгийн 1, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 124,606.2 мянган төгрөгийн 7 шийдвэрийг тус тус мэдээлээгүй.	1	-						1				
Нийт		2	24,932.0	0	-	1	24,932.0	1	-	-	-		